


ОРХОН АЙМГИЙН ИТХ-ЫН СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ  
ХАНДАА ОВОГТОЙ ЖАРГАЛАНБААТАР СОНГУУЛИЙН  
МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Сонгуулийн уриа: Эрдэнэтчүүд бид эхлүүлж чадна.

Энэхүү мөрийн хөтөлбөр нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль болон бусад эрх зүйн актуудын хүрээнд боловсруулагдсан ба хэрвээ ИТХ-д сонгогдсон тохиолдолд төлөөлөгчийн хувьд Эрдэнэт хотын хэмжээнд хийж хэрэгжүүлэх зорилтот ажлууд мөн тухайн нэр дэвшигчийн нэр дэвших баг дээр хийж хэрэгжүүлэх, шийдвэрлэх зорилтуудыг 2 хэсэгт багтаан томъёолж өгсөн болно.

Зорилт 1. Орон нутагтаа буюу Эрдэнэт хотын хэмжээнд хийж хэрэгжүүлэх ажлууд:

- 1.1. Эрдэнэт хотод төрж, өссөн, ажиллаж амьдарч байгаа иргэд байгалийн баялагтаа эзэн байх, үр шимийг нь хүртдэг байх талаар Эрдэнэт хотоос УИХ-д сонгогдсон гишүүдтэй хамтран ажиллаж, эрх зүйн орчинг нь бүрдүүлнэ.
- 1.2. Хөдөлмөрийн насны ажил хөдөлмөр эрхлэх чадвартай иргэдийг ажлын байраар хангах, ажлын байр олноор бий болгох тал дээр бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.3. Эрдэнэт хотынхоо иргэдийн амьжиргааг дэмжих, бага орлоготой иргэдэд чиглэсэн тусгай хөтөлбөр боловсруулж өөрсдийнх нь оролцоог хангаж хэрэгжүүлнэ.
- 1.4. Орон нутагтаа ажлын байр нэмэгдүүлэх гол эх үүсвэр нь жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг олноор бий болгохтой холбогдох ба энэ чиглэлд ЖДҮсан болон Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэл, үйлчилгээний дэмжих бусад дэмжлэгийн сангуудын үйл ажиллагааг ил тод хүртээмжтэй байхад анхаарч дэмжиж ажиллана.
- 1.5. Үйлдвэр түшиглэсэн хотын хувьд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ болон Эрдэнэт хотын ИТХ, ЗДТГ-ын зүгээс хамтран ажиллах гэрээг шинэчлэн боловсруулж гадаад улсаас импортоор авдаг бараа бүтээгдэхүүнийг Эрдэнэт хотдоо үйлдвэрлэж байгаа хувь хүн, аж ахуйн нэгжүүдийг бүрэн дүүрэн дэмжиж ажиллах эрх зүйн орчинг бүрдүүлж хэрэгжүүлнэ.
- 1.6. Эрдэнэт хотын захиргаа, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын хамтын ажиллагааны гэрээний хүрээнд байгаль экологийн орчны бохирдлоос хүн, мал, амьтны эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй асуудлууд болон гол ус, хөрсний бохирдол, Цагаан тоосыг арилгах тал дээр онцгой анхаарч ажиллана.
- 1.7. Хотынхоо хүн амын өсөлт, хөгжилтөнд маш чухал шаардагдаж байгаа сургууль, цэцэрлэгийн хангалт хүртээмжийг нэмэгдүүлэх тал дээр үе шаттай бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.8. Иргэдийнхээ эрүүл мэндийн чиглэлээр Бүсийн оношлогоо эмчилгээний төв, Медипас оношлогоо эмчилгээний төв зэрэг иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж буй эмнэлгүүдийн ажиллах нөхцлийг сайжруулах, орчин үеийн шинэлэг зайлшгүй техник, тоног төхөөрөмжөөр хангах, эмч эмнэлгийн ажилтнуудыг давтан сургах, эрүүл мэндийн үйлчилгээг иргэд саадгүй түргэн шуурхай авч байх тал дээр анхаарч ажиллана.



- 1.9. Иргэдэд анхан шатны эмнэлгийн тусламж үзүүлдэг Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг зориулалтын байр, техник, тоног төхөөрөмжтэй болгох бодлого хэрэгжүүлэхэд анхаарч ажиллана.
- 1.10. Гэр хороололд амьдарч буй иргэдэд байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй бие засах байртай болгох талаар холбогдох газруудад хандах, тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор цэвэр, бохирын шугам, халаалтын асуудлыг шийдвэрлэх чиглэлээр УИХ, ЗГ, холбогдох яамд, олон улсын банк санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллана. Хог хаягдлын зохистой менежментийг сайжруулж, хог боловсруулах үйлдвэрийг дэмжиж ажиллана.
- 1.11. Орон сууцны хорооллууд дундах авто зам болон зогсоол, явган замыг өргөтгөж, зам талбайг зөв зохистой тохижилтийг хийлгэхэд санал санаачлага гаргах, нэвтрүүлэх чадавхийг дээшлүүлэх, Гэр хорооллын асфальтан болон сайжруулсан авто болон явган замыг үе шаттайгаар нэмэгдүүлэхэд бодлогыг боловсруулж, уламжлах.
- 1.12. Иргэдийн эрүүл зөв дадал зуршлыг дэмжих зорилгоор хотын төв болон бусад хэсэгт дугуйн замтай болох ажлыг эхлүүлж мэргэжлийн байгууллагаар зураг төсөл, холбогдох судалгааг хийлгэхэд үйл ажиллагаагаа чиглүүлнэ.
- 1.13. Нийтийн тээврийн үйлчилгээний менежментийг сайжруулж, тээвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, соёлтой зөв үйлчилгээг иргэдэд хүргэхэд идвэхитэй оролцоно. Хот хоорондын зорчигч тээврийн Авто вокзалтай болох асуудлыг холбогдох чиглэлээр нь хамтран хэрэгжүүлнэ.
- 1.14. Нийтийн биеийн тамир, спортын үйл ажиллагааг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй клубүүд, спортын холбоодын зохион байгуулалтыг бодлогоор дэмжиж ажиллана.
- 1.15. Хүүхэд багачуудын чөлөөт цагаа спортоор хичээллэж, ая тухтай өнгөрөөх, зориулалттай чийрэгжүүлэх тоглоомын талбайг хотын төвийн болон гэр хорооллын багуудаар үргэлжлүүлэн хийж байгаа ажлыг дэмжинэ.
- 1.16. Хотын суурьшлын хүрээ өргөжин тэлж байгаа, мөн ДЦС-ын өргөтгөл хийгдэж, Цэвэрлэх байгууламжийн хүчин чадал нэмэгдэж байгаатай холбогдуулан хотын хуучирсан инженерийн шугам сүлжээг үе шаттай солих ажлыг дэмжинэ.
- 1.17. Эрдэнэт хотын бүтээн байгуулалтанд оролцсон, Эрдэнэт үйлдвэрийг барьж байгуулсан Илгээлтийн эзэд, Анхдагчид руу хандсан бодлогыг шинэчлэн хэрэгжүүлнэ.
- 1.18. Ахмад, Эмэгтэйчүүд, Залуучууд, Хүүхдүүдрүү хандсан нийгмийн харилцааг зохицуулах, дэмжсэн дэд хөтөлбөрүүд боловсруулан хэрэгжүүлнэ. Өндөр настан, харж хандах хүнгүй иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд рүү хандсан нийгмийн дэмжлэгийг чирэгдэлгүй хүргэх тал дээр онцгойлон анхаарч ажиллана.
- 1.19. Орон нутагт үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа иргэдийн үйл ажиллагааг дэмжих, дотоод зах зээлийг дэмжих, иргэдийн хүнсний хэрэглээ болон бараа бүтээгдэхүүний чанартай, аюулгүй байдалд онцгой анхаарч эрх зүйн бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.20. Эрдэнэт хотын төвийн болон захын хорооллуудын үер усны амыг, болзошгүй аюулаас хамгаалах үерийн хамгаалалтын далан барих асуудалд онцгой анхаарч дэмжиж ажиллана.
- 1.21. Хотын иргэдийнхээ ая тухтай ажиллаж, амьдрах, амрах орчинг бүрдүүлэхэд санал санаачлага гарган дуу хоолой болж ажиллах, аюулгүй байдалд анхаарч камержуулалтын системийн хүрээг нэмэгдүүлэх, хууль сахиулах онцгой чиг үүрэг бүхий байгууллагуудыг шаардлагатай техник хэрэгслээр дэмжиж, бэлэн байдлыг хангуулахад хамтран ажиллана.
- 1.22. Орхон аймаг нь Эрдэнэт хот болж байгаатай уялдуулан Хотын соёлыг түгээх, хотын хөгжлийн шинэлэг бодлого, санаачлагыг дэвшүүлж, хотын хөгжил,

төлөвшлийн аливаа уриалгыг нийгэмд түгээж, ажиллах хөгжлийн төлөөх сайн санал, санаачлагыг дэмжиж хамтран ажиллана.

## Зорилт 2. Багийн хэмжээнд хийж хэрэгжүүлэх ажлууд.

2.1. Орон сууц, амины орон сууц, хашаа байшинтай холбогдож байгаа төвийн шугамын хуучирч муудсан инженерийн шугам сүлжээг үе шаттай засварлах, солих ажлыг дэмжинэ.

2.2. Орон сууцны байрнуудын дээвэр, заадсын засвар, халаалт дулаан алдагдлыг чанартай, түргэн шуурхай, баталгаатай гүйцэтгэдэг байх Оршин суугчид өөрсдөө хяналт тавьдаг зохицуулалтыг хангана.

2.3. Орон сууц, гэр хорооллын гудамжин дундах хүүхдийн тоглоомын талбайн ашиглалтыг сайжруулах, эрүүл ахуйн шаардлага хангасан материал, тоноглол хийхэд анхаарлаа хандуулж, хяналт тавих, засаж тохижуулах, үе шаттай нэмэгдүүлэхэд анхаарна.

2.4. Гудамж дундах гарц, гарам авто замын нэвтрүүлэх чадавхийг нэмэгдүүлж, өргөтгөх, авто зогсоолын хүртээмжийг нэмэгдүүлэх, явган замыг сайжруулах, үерийн ус зайлуулах шугмын ажлыг хийх асуудлыг шийдвэрлэхэд бодлогоор дэмжлэг үзүүлнэ.

2.5. Багийн иргэдэд үйлчилгээ үзүүлдэг багийн ЗД-ын ажлын алба, Цагдаагийн хэсэг, Өрхийн эмнэлэгийн ажиллах нөхцлийг сайжруулж, иргэдэд төрийн үйлчилгээг хүнд сурталгүй, зөв мэдээллээр хангах, үйлчилгээг түргэн шуурхай хүргэдэг зохицуулалтыг бий болгоно.

2.6. Багийн хэмжээнд ахмад настны хөгжлийн төв, залуусын чөлөөт цагийн төв, нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэх төв, эцэг эхчүүд гэр бүлд зориулсан төв байгуулах зэрэг аливаа үүсгэл санаачлагыг дэмжиж ажиллана.


2.7. Багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийн үйлдвэрлэл, үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудтай нягт уялдаатай ажиллаж, эрүүл мэндийн яаралтай тусламж үзүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор эмийн сангийн хүрэлцээг нэмэгдүүлэхэд Багийн болон харъяалагдах салбарынханд уламжлах, бодлогоор дэмжинэ.

2.8. Багийн харъяалал бүхий ажил хөдөлмөр идэвхитэй хайж байгаа иргэдэд туслах зорилго бүхий Хөдөлмөрийн бирж ажиллуулах бодлого зохицуулалт хийнэ.

2.9. Багийн нутаг дэвсгэрт буй ногоон байгууламж, тохижилтийг цаашид үе шаттай нэмэгдүүлж, багийн иргэд өөрсдөө оролцож мод, бут тарьж ургуулдаг боложийг нээж өгнө.


2.10. Багийн нутаг дэвсгэр дэхь сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх тал дээр байнга анхаарч ажиллана.

2.11. Ахмад настан, харж хандах хүнгүй иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан автобусны буудал, замын хажуугийн шат, гүүр, зам, гарц болон бусад

A handwritten signature in black ink is written over a red rectangular stamp. The signature is cursive and appears to be a name. The stamp is partially obscured by the signature.

нийгмийн бүхий л дэмжлэгийг чирэгдэлгүй хүргэх ажилд онцгой анхаарал хандуулан ажиллана.

2.12. Орхон аймаг нь Эрдэнэт хот болж байгаатай холбогдуулан багийн хэмжээнд хотын соёлыг түгээх, орчны гэрэлтүүлэг, тохижилт, зам гүүрийн хашлага хамгаалалт, байр, сууцны хаягжуулалт, соён гэгээрүүлэх ажлуудыг иргэдийн шууд оролцоотойгоор өргөн хүрээнд зохион байгуулна.

Мөрийн хөтөлбөрийг боловсруулсан : .....Х.Жаргаланбаатар

2020.07.23